




Дэлхийн өрсөлдөх чадварын 2015-2016 оны тайлан дахь Монгол Улсын зэрэглэл сайжраагүй байна

Дэлхийн эдийн засгийн форум өөрийн жил бүр эрхлэн гаргадаг Өрсөлдөх чадварын 2015-2016 оны тайлангийн дүнг 9 дүгээр сарын 30-нд дэлхий даяар танилцуулав. Үүнтэй холбогдуулан тус байгууллагын түншээр 11 дэх жилдээ ажиллаж буй Нээлттэй нийгэм форум энэхүү тайланд багтдаг Монгол Улсын зэрэглэлийг танилцуулж байна.

Өрсөлдөх чадварын индексээр дэлхийн 140 гаруй орныг өрсөлдөх чадварыг тодорхойлогч 12 тулгуур хүчин зүйл дээр үндэслэн эрэмбэлдэг. Уг индекс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл бөгөөд тус тайлангийн дүнг улс орнууд анхааралтай авч үзэж өрсөлдөх чадвараа сайжруулах бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг байна. Манай улс 2005 оноос энэхүү тайланд нэгдэж, өрсөлдөх чадварын түвшингээ дэлхийн улс орнуудтай харьцуулах боломжтой болсон юм.

Энэ жилийн тайлан судалгаагаар Монгол Улсын өрсөлдөх чадварын түвшинд ахиц гараагүй байна. Манай улс авбал зохих 7 онооноос 3.8 оноо авсанаар судалгаанд хамрагдсан 140 орноос 104-рт эрэмблэгджээ. Судалгаанд хамрагдсанаас хойшхи хугацаанд манай улс 3.2-3.9 оноо авсан нь өрсөлдөх чадварын хувьд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.

Монгол Улсын Өрсөлдөх чадварын оноо, зэрэглэл, 2005-2015 он




Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд дээр үндэслэн нэгтгэв.

Өрсөлдөх чадварыг тодорхойлогч 12 тулгуур үзүүлэлтээс Монгол улсын хувьд 2015 онд 5 үзүүлэлтийн хувьд ахиц гарсан байна. Өмнөх онтой харьцуулахад технологийн бэлэн байдлын үзүүлэлт 0,5 оноогоор, зах зээлийн хэмжээ 0,3 оноогоор, институциудын чанар болон инноваци тус бүр 0,2 оноогоор, дээд боловсрол ба мэргэжлийн сургалт 0,1 оноогоор өссөн байна. Технологийн бэлэн байдлын үзүүлэлтийн түвшний өсөлтөд үүрэн телефон утас хэрэглэгчдийн тоо, интернэтийн хурд болон хэрэглэгчийн тоо өссөн нь нааштай нөлөө үзүүлжээ. Институциудын чанарын түвшний өсөлтөд оюуны өмчийн хамгаалалт, улсын хөрөнгийн ашиглалт, шүүхийн хараат бус байдал, төр, засгийн зохицуулалтын талаар гомдол гаргах хууль эрх зүйн орчны үр ашигтай байдал зэрэг үзүүлэлтүүдэд бага зэрэг ахиц гарсан нь нөлөөлжээ.

Харин өрсөлдөх чадварын 3 үзүүлэлтийн түвшин буурчээ. Эдгээрээс макро эдийн засгийн тогтвортой байдал хамгийн их буюу 0,6 оноогоор, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал 0,2 оноогоор, эрүүл мэнд, бага боловсрол 0,1 оноогоор буурчээ. Макро эдийн засгийн тогтвортой байдлын түвшин буурахад улсын төсвийн алдагдал 2014 онд дотоодын нийт бүтээгдэхүүн(ДНБ)-ий 11%-д хүрсэн, ДНБ-д эзлэх үндэсний хуримтлалын хэмжээ 24,3% болж буурсан, ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээ 75.5% болсон, инфляци өссөн, улсын зээлийн үнэлгээ буурсан нь нөлөөлжээ.

Эдгээр 12 үзүүлэлтээс макро эдийн засгийн тогтвортой байдал, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн боловсронгуй байдал, инноваци зэрэг 5 үзүүлэлтээр авбал зохих онооны 50 хувьд ч хүрч чадаагүй байна.

Монгол Улсын өрсөлдөх чадварын оноо, 2015-2016 он (12 тулгуур үзүүлэлтээр)



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд дээр үндэслэн нэгтгэв.


Өрсөлдөх чадварын индексийн 12 тулгуур үзүүлэлтийг бүрдүүлдэг 115 дэд үзүүлэлтээс манай улс 140 гаруй орноос 10 гаруй үзүүлэлтээр эхний 50 байрт багтсан нь тэмдэглүүштэй юм. Эдгээрээс дурдвал, цалин хөлс тогтооход уян хатан байдал (9-р байр),

хөрөнгө оруулагчийн хамгаалалт (14-р байр), татварын нийт хувь хэмжээ (22-р байр), бизнес эхлэн эрхлэхэд шаардагдах журмын тоо (38-р байр), цалин хөлс ба бүтээмж (39-р байр), ДНБ-д эзлэх үндэсний хуримтлалын хувь хэмжээ (44-р байр) зэрэг юм.

Азийн хөгжиж буй орнуудтай харьцуулахад манай улс дээд боловсрол ба мэргэжлийн сургалт болон технологийн бэлэн байдал гэсэн үзүүлэлтүүдээр давуу байна. Харин дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил, макро эдийн засгийн орчин, зах зээлийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр эдгээр орноос доогуур түвшинд байна.

Өрсөлдөх чадварын индексээр улс орнуудыг Заяагдмал нөөцөд тулгуурласан эдийн засагтай (хөгжлийн доод түвшин), Үр ашигт тулгуурласан эдийн засагтай (хөгжлийн 2-р түвшин), Инновацид тулгуурласан эдийн засагтай (хөгжлийн дээд түвшин) гэсэн хөгжлийн 3 түвшинд хуваан авч үздэг. Монгол Улс Заяагдмал нөөцөд тулгуурласан эдийн засагтай улс орноос Үр ашигт тулгуурласан эдийн засагтай улсын түвшин рүү шилжиж буй орнуудын ангилалд багтсан хэвээр байна. Энэ ангилалд Азербайджан, Бутан, Казахстан, Кувейт, Вьетнам зэрэг 16 орон багтаж байна. Манай улсын хувьд институциудын чанар, дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил болон технологийн бэлэн байдал гэсэн үзүүлэлтүүдийг сайжруулах нь өрсөлдөх чадварыг дээшлүүлж, Үр ашигт тулгуурласан эдийн засагтай орон болоход чухал юм.

Өрсөлдөх чадварын индексийг тооцохдоо статистик мэдээ болон тухайн улсын Бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгын дүнг ашигладаг. Өрсөлдөх чадварын судалгааны хүрээнд Бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгын дүнд үндэслэн тухайн улсад бизнес эрхлэхэд саад болж буй гол хүчин зүйлсийг мөн тодорхойлон гаргадаг. 2015 оны судалгаагаар Монгол улсад бизнес эрхлэхэд саад учруулж буй хүчин зүйлсэд засгийн газрын тогтворгүй байдал, төрийн хүнд суртал, санхүүжилт авах боломж, инфляци, мэргэшсэн ажиллах хүчний дутагдал, бодлогын тогтворгүй байдал зэрэг үзүүлэлтүүд багтсан байна.



Өндөр хөгжилтэй орнууд болох Швейцар, Сингапур, АНУ, Герман, Нидерланд, Япон зэрэг улсууд өрсөлдөх чадвараараа дэлхийд тэргүүлж байна. Эдгээр орнуудын хувьд төрийн институциудын үр ашигтай, ил тод байдал, макро эдийн засгийн тогтвортой байдал, боловсролын чанар, бизнесийн төгөлдөршил, инноваци гаргах чадвар өндөр байна. Харин манай урд хөрш Хятад улс 4.89 оноогоор 28-рт, хойд хөрш Орос улс 4.44 оноогоор 45-рт эрэмблэгдсэн байна.

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улс өрсөлдөх чадварын хувьд авбал зохих онооноос дөнгөж талаас илүү хувийг авсан нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар дорвитой ахиц гаргах шаардлагатай байгааг харуулж байна. Ялангуяа засаглалын асуудлууд болох институциудын чанар, үүн дотроо төрийн албан тушаалтны ашиг, сонирхлын зөрчлийн асуудал, улсын хөрөнгийн ашиглалт зэрэг асуудлуудад нэн тэргүүнд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Өрсөлдөх чадварын индексийн дүн нь засгийн газар, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Дэлхийн өрсөлдөх чадварын 2015-2016 оны тайланг
<http://reports.weforum.org/global-competitiveness-report-2015-2016/>
хуудаснаас үзнэ үү.

Нээлттэй Нийгэм Форум
Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер
Д.Оюунбадам
Утас:313207